

Үхэгсэд Их Эзэнийг магтахгүй, Түүнд талархахгүй



*“Эргээд ирээч, ИАВЭ!
Амийг минь хамгаалаач.
Энэрэл журмаа бодож намайг авраач.
Үхдэл болчихвол яахан Таныг дурсах билээ?
Үхэгсдийн орноос хэн Танд талархах билээ?”
(Дуулал 6:4-5)*

Израилын хамгийн алдартай хаан болох Давидын энэ үгийг уншихдаа та над шиг цочсон уу? Давид бол Мөнхийн Эзэний “зүрх сэтгэлд нийцэх хүн” мөн (1 Самуел 13:14). Мянга жилийн дараа буюу Есүс Христийг энэ дэлхий дээр байх үед ч иудейчүүд Давид хааныг мөн Ертөнцийн Эзэний “сэтгэлийн дагуух хүн” гэдгээр санан дурсаж байв (Үйлс 13:22).



Тийм байхад Давид хаан яагаад нас барсныхаа дараа Мөнхийн Эзэнийг санахгүй, Түүнд талархахгүй гэж хэлсэн юм бэ?

Давидын бас нэгэн гуйлтыг уншъя (Дуулал 30:9):

“Аяа ИАВЭ, Таныг би дуудлаа.

Ая тааллыг Эзэнээс би эрлээ.

Нүх рүү одлоо гээд үхлээс минь ашиг юун!

Шороо тоос нь Танд талархах биш дээ!

Сэтгэлийн тань үнэнчийг тунхаглах ч биш.”

Еврей хэл уран дүрслэлийн үг хэллэг ихтэй. Энд “шороо тоос” гэсэн нь “газар шороонд булагдсан буюу үхсэн хүмүүсийг” хэлж байгаа нь хам сэдвээс тодорхой (СМО-ын тайлбарыг үзнэ үү). Нас барсан хүн Мөнхийн Эзэнд талархдаггүй гэнэ. Амьсгал хураасан хүн Түүний юутай үнэнч болохыг бусдад ярьж өгдөггүй гэнэ. Энэ үгс Давид хааны амнаас гараад зогсохгүй, Ертөнцийн Эзэний Үгийн хэсэг болж мөнхөрсөн шүү дээ.

Тэгвэл энэ үг ямар учиртай вэ? Давид хаан нас барсныхаа дараа тэнгэрийн улсад орж, хамгаас их хайрт Эзэнтэйгээ нүүр тулан уулзаж, Түүнийгээ өмнөхөөсөө ч илүү ихээр магтахгүй гэж үү? Тийш очиж, өөрөөс нь өмнө өнгөрсөн хайртай аав ээжтэйгээ уулзаж, Абрахам, Мосе, Иошуа зэрэг алдартай өвөг дээдэстэйгээ



танилцахгүй гэж үү? Тэдэнтэй Их Эзний үнэнч сэтгэлийн тухай ярилцахгүй гэж үү?

Үгүй ээ, Давид хаан тэнгэрийн улсад очоогүй. Үүнийг баттай хэлж болох шалтгаан бий. Үүнд: “Хүний Хүүгээс [=Есүсээс] өөр тэнгэрт дээш гарсан хүн нэг ч үгүй” гэж Есүс Их Эзэн Өөрөө хэлсэн учраас тэр (Иохан 3:13).

Дээр нь апостол элч Петр иудейчүүдэд Христийн үхлээс амилж, тэнгэр өөд одож, тэнд “Бурханы баруун гарт өргөмжлөгд”-сөн тухай ярихдаа Давид хааныг тэнгэр өөд яваагүйг онцлон хэлсэн. Ингэхдээ:

“Ах дүү нар аа, өвөг Давидын тухайд би та нарт итгэлтэйгээр хэлэхэд тэр үхэж, оршуулагдаад, булш нь өдгөөг хүртэл бидний дунд байна. (...)

...тэнгэрт гарсан нь Давид биш” гэжээ (Үйлс 2:29+34).

Давид Хааны булш өнөөдөр ч Иерусалим хотод байдаг (хажуу дахь зураг үзнэ үү).





Тэгвэл Давид хаан одоо хаана байгаа вэ?
Үхэгсдийн хаана байхыг Иов ч гэсэн эрт дээр
үед асуужээ (Иов 14:10). Үүнд: *“Хүн бол үхнэ,
өнхрөөд өгнө. Тэрээр дуусна, тэгээд хаана
байна вэ?”*

Энэ асуулт нь авралын зар тараах семинарт
суусан хүнд танил мэт сонсогдоно. “Та өнөөдөр
нас барвал хаашаа явах вэ? Тэнгэр лүү юу там
руу юу?” гэж авралын зар тараахдаа асуудаг
байхыг заах нь түгээмэл.

Ертөнцийн Эзний Үг энэ асуултанд аль хэдийн
хариу өгсөн. Та анхааралтай уншаарай:

“Зөвт ба буруут, сайн ба муу...

аль алинд нь

нэг л хувь тавилан тохиодог аж.

Нарт хорвоод болж буй бүхний дунд

хүн бүрд нэг л тавилан байдаг нь

харуусам явдал юм...

Амьд байгаа нь үхнэ гэдгээ мэднэ.

Амьгүй нэгэн юуг ч үл мэднэ...

Тэдний хайр, хорсол,

атаа жөтөө нь ч мөхөж

Нарт хорвоод болж буй бүхэнд

цаашид эс оролцоно...

Хийхийг зорьсон бүхнээ

хамаг чадлаараа одоо хий.



*Чиний очих үхэгсдийн оронд
ажил үйлс, учир шалтгаан,
мэдлэг ойлголт, мэргэн ухаан гэж үгүй...”*
(Гүн ухаантны үг 9:2-6,10)

Үүнээс харахад үхэгсдийн очих газар тодорхой юм. Бүгд адилхан хувь тавилантай. Сайн муу ялгаагүй бүгд булшинд орж тэнд юу ч мэдэхгүй, юу ч бодохгүй, юу ч хийхгүй, юу ч мэдрэхгүй. Амьгүй хүн Ертөнцийн Эзэнийг ч магтаж чадахгүй. Давид хааны дээрх үг бодит үнэнийг агуулжээ.

Давид хаан одоо хаана байна вэ?

Давид хаан одоо хаана байгаа вэ гэвэл, үхэгсдийн оронд буюу булшны “нүх”-энд. Булш нь өнөөг хүртэл Иерусалимд байдаг. “Давидын хувьд тэр тухайн үедээ Бурханы зорилгод үйлчилж байгаад нойрсож, эцэг өвгөдийнхөө дунд тавигдан, ялзралыг үзсэн билээ” (Үйлс 13:36). Тэнд Давид хаан өнөөдөр үхдлийн үлдээсэн тоос шорооны байдлаар л байна. Хүний амь сүнс эргээд Бүтээгч Эзэндээ очдог ч гэсэн хүн өөрөө эргээд хөрс шороонд буцах тавилантай. Энэ бол Ертөнцийн Эзэний тогтоол юм. Үүнд:
“Хөрс шорооноос гарсан чи эргээд тийшээ буцна... Тоос шороо учир чи тоос шороондоо



буцна” (Эхлэл 3:19; Номлогчийн үгс 12:7).
Үхэгсдийн орон бол булш бунхан буюу “хадан гэр”-ийг хэлнэ.

Үхэгсдийн оронд хүн “хэвтрээ засан” анир чимээгүй харанхуйд гүн нойрсдог гэсэн уран дүрслэлээр үхэгсэд ухаангүй байдгийг илэрхийлнэ. Тийм учраас Үхэгсдийн орныг мөн “Мартахуйн газар” гэж нэрлэсэн бий (Дуулал 139:8; 88:6+12; 115:17; 13:3 АБ2019). Үүнийг нэгэн Дуулал бичигч бас доорх үгээр шууд илэрхийлсэн байна (Дуулал 146:4):

*“Амьсгал хурааж шороондоо тэр буцна.
Аяа, тэр л өдөр
бодол төлөвлөгөө нь устана...”*

Ертөнцийн Эзэний энэ цочирдмоор үгийг уншихад, Иовын тавьсан бас нэгэн асуултыг бид өөрийн эрхгүй асууна (Иов 14:14):

“Хүн үхлээ гэхэд эргээд амьдрах уу?”

Давид хаанд лав энэ итгэл найдвар байсан. Мөнхийн Эзэнд тэр хандан хэлэхдээ (Дуулал 16:10-11):

*“Бодол санаа минь баясаж,
хүсэл сэтгэл минь хөөрнө.
Бие махбод минь ч
амар жимэр аж төрнө.*



*Учир нь Та намайг
Үхэгсдийн оронд
орхихгүй.
Үнэн журамт нэгэндээ
булшны нүхийг
үзүүлэхгүй.
Амийн замыг Та
надад мэдүүлнэ.
Ариун оршихуйд тань
баяр хөөр бялхана.
Таны баруун мутарт
таалал баясал
ямагт оршдог.”*



Эдгээр мөртөөр Давид хаан эхний ээлжинд өөрийн үр хойч нь болох Есүс Христийн тухай зөгнөн хэлсэн юм (Петрийн тайлбарласнаар: Үйлс 2:25-32). Есүс бол үхээд дахин амилж үхэшгүй амьтай болсон анхны хүн билээ. Бичвэрүүдэд өгүүлсэн уран зүйрлэлээр, “Христ... нойрсогсдын анхны үр жимс мөн” (1 Коринт 15:20).

Есүс нас барж дахин амилсан нь ихэд учиртай. Учир нь, Түүний үхэл, амиллаар дамжин “үхлийн хүч” буюу үхлийн ертөнцийг захирах эрх мэдэл Түүний гарт оржээ. Есүс “үхлийн хүчийг баригч буюу диаволыг [=Сатаныг] үхлээрээ хүчгүй



*болгоод, бүх насаар үхлийн айдаст
боолчлогдож байсан бүгдийг чөлөөлөх юм”*
(Еврей 2:14-15).

“Үхлийн ба Үхэгсдийн орны түлхүүр” одоо
Есүсийн гарт байгаа учраас бид үхлээс айх
хэрэггүй болсон (Илчлэл 1:18).

Тийм учраас “*Үхэгсэд Бурханы Хүүгийн дууг
сонсох цаг ирж байгаа...*

Сонссон нь амилах болно...

*Булшинд байгчид бүгдээрээ Түүний дууг сонсон
гарч ирэх цаг ирж байна”* гэж Есүс Өөрөө хэлсэн
(Иохан 5:25+28-29).

Хаадын Хаан Есүс үнэнч зарц Давидаа
Үхэгсдийн оронд орхихгүй нь лавтай. Одоо ч
Ертөнцийн Эзэн Үхэгсдийн оронд ч байна
(Дуулал 139:8).

Цаг нь болохоор Давид хаан Их Хаан Есүсийн
дуу хоолойг сонсож дахин амилах болно. □

*Дараагийн нийтлэлдээ Библи хүний бүтцийн
тухай юу заадгийг авч үзнэ. Бичвэрийн дагуу хүнд
сэтгэл байхгүй, хүн өөрөө “амьд сэтгэл” юм.*



Хэрэглэсэн эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org